



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/370

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1.2, "Аймгийн 2021 оны төсөв батлах тухай" аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 сарын 02-ны өдрийн 03/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд Баянтээгийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн шахмал түлш үйлдвэрлэх технологийн туршилтын ажилд 16,800,000 (арван зургаан сая найман зуун мянга) төгрөг, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан боловсруулах зардалд 11,747,340 (арван нэгэн сая долоон зуун дөчин долоон мянга гурван зуун дөч) төгрөг нийт 28,547,340 (хорин найман сая таван зуун дөчин долоон мянга гурван зуун дөч) төгрөг зарцуулсугай.

2. Дээрх зардал 28,547,340 (хорин найман сая таван зуун дөчин долоон мянга гурван зуун дөч) төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтын "Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний зардал"-аас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100783